



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/131

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/17 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх авто зам, зам засварын ажлын жагсаалтыг 1 дүгээр, тохижилт, гэрэлтүүлэг, камержуулалт, бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг 2 дугаар, сургууль, цэцэрлэгийн техник тоног, тэхээрөмжийн ажлыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ захирамжийн хавсралтуудад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ж.Сандагсүрэнд шилжүүлэн, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

3. Энэ захирамжийн хавсралтуудад заасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Ж.Тогтохбаяр/-т, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т, 3 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однасан/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ

Ж.БАТБАЯСГАЛАН

111020000644

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
 02 сарын 26-ны өдрийн
 АТБЗ дүм захирамжийн
 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
 ХӨРӨНГӨӨР 2019 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ АВТО ЗАМ,
 ЗАМ ЗАСВАРЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	/сая төг/
				2019 онд санхүүжих дүн
1	Авто замын засварын ажил /СХД, 25 дугаар хороо/	2019	40.0	40.0
2	119 дүгээр цэцэрлэгийн ард авто машины зогсоол хийх /СХД, 16 дугаар хороо/	2019	15.0	15.0
3	24 дүгээр байрны замыг нэг чигийн урсгалтай болгох /СХД, 16 дугаар хороо/	2019	35.0	35.0
4	Орон сууцны хорооллын зам засвар /СХД, 16 дугаар хороо/	2019	40.0	40.0
5	113 дугаар цэцэрлэг рүү орох замыг өргөтгөх /СХД, 16 дугаар хороо/	2019	10.0	10.0
6	34б байр руу орох замыг өргөтгөж, хатуу хучилттай болгох /СХД, 17 дугаар хороо/	2019	50.0	50.0
7	32 дугаар байр орчмын авто замын засвар, авто зогсоол байгуулах /СХД, 17 дугаар хороо/	2019	50.0	50.0
8	Орон сууцны хорооллын зам засвар /СХД, 29 дүгээр хороо/	2019	100.0	100.0
9	"Хөтөл трейд" дэлгүүрээс 2-60 дугаар байрны зүүн өнцөг хүртэл автозам /СХД, 18 дугаар хороо/	2019	100.0	100.0
	ДҮН		440.0	440.0

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
...*2021*... сарын *26*-ны өдрийн
...*А.Н.Т. Г. Г. Г.*... захирамжийн
2 дугаар хавсралт

ТОХИЖИЛТ, ГЭРЭЛТҮҮЛЭГ, КАМЕРЖУУЛАЛТ, БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	/сая төг/
				2019 онд санхүүжих дүн
1	Гэрэлтүүлэг /СХД, 1, 2, 3 дугаар хороо/	2019	400.0	400.0
2	104 дүгээр сургууль, 17 дугаар цэцэрлэгийн камержуулалт /СХД, 25 дугаар хороо/	2019	20.0	20.0
3	Камержуулалт /СХД, 8 дугаар хороо/	2019	20.0	20.0
4	163 дугаар цэцэрлэгийн тоглоомын талбайг тохижуулах /СХД, 25 дугаар хороо/	2019	10.0	10.0
5	76 дугаар сургуулийн биеийн тамирын заалны засвар /СХД, 9 дүгээр хороо/	2019	35.0	35.0
6	Өрхийн эрүүл мэндийн төвийн засварын ажил /СХД, 8, 9, 25 дугаар хороо/	2019	50.0	50.0
7	Ахмад настан, хүүхэд залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийтийн биеийн тамир, амралт, соёл үйлчилгээний төв /СХД, 25 дугаар хороо/	2019	195.0	195.0
8	Гэрэлтүүлэг /СХД, 23 дугаар хороо/	2019	100.0	100.0
9	Тохижилтын ажил /СХД, 19 дүгээр хороо/	2019	50.0	50.0
10	5 дугаар бааз гудамжинд хүүхдийн тоглоомын талбай /СХД 20 дугаар хороо/	2019	50.0	50.0
11	Нефть Толгойтын уулзвараас шинэ Цэргийн хотхоны 9 дүгээр байр хүртэлх гэрэлтүүлэг /26 ш/ /СХД 20 дугаар хороо/	2019	50.0	50.0
12	Камержуулалт 5 дугаар бааз, Төмөр зам, Нефть, Хуучин Цэргийн хотхон /15 ш/ /СХД 20 дугаар хороо/	2019	50.0	50.0
13	Гэрэлтүүлэг /СХД 30 дугаар хороо/	2019	50.0	50.0
14	Сагсан бөмбөгийн талбайн тохижилт /СХД 30 дугаар хороо/	2019	50.0	50.0
	ДҮН		1,130.0	1,130.0

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
02 дугаар сарын 26-ны өдрийн
А.1131 дүмт захирамжийн
3 дугаар хавсралт

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ТЕХНИК ТОНОГ,
ТӨХӨӨРӨМЖИЙН АЖИЛ

				/сая төг/
№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих дүн
1	Сургууль, цэцэрлэгийн техник тоног, төхөөрөмж /СХД, 8, 9, 25 дугаар хороо/	2019	30.0	30.0
	ДҮН		30.0	30.0